

## Шүүх хянан байцаах хэлтэс

1925-12-11-нд Засгийн газрын 44-р хурлаар Хотын захиргааг жинхэнэ болгож, дүрмийг улсын бага хурлын тэргүүлэгчдэд явуулан батлуулахаар тогтоожээ.

1925-12-11-нд Улсын 2 дугаар Их хурлаар хотын захиргааны дүрэм дөчин есөн зүйлийг баталсан байна.

Хотын захиргааны гүйцэтгэх газар нь долоон тэргүүлэгчидтэй, түүний дарга, орлогч, нарийн бичгийн дарга нар нь товчоо болон бүрэлдэж байсан бөгөөд хэлтсүүд нь Ерөнхий хэлтэс, Ардыг гэгээрүүлэх хэлтэс, Ардын эрүүлийг сахих хэлтэс, Аж үйлдвэрийн хэлтэс /энэхүү хэлтэст санхүү, аж ахуй, тоо бүртгэх салбарууд хамаарагдаж байв/-тэй байхаар заажээ. Хэлтсүүд нь тухайн үеийн байдлаас өөрчлөгдөж байжээ. Албан газар, цэрэг, үйлдвэрийн хэлтсүүдтэй болсон байна.

1925 онд хотын захиргаа нь 6 хэлтэс, 104 орон тоотой байв.

1930 онд батлагдсан Улаанбаатар хотын захиргааны дүрмийг шинэчлэн баталж, эл дүрэмд хотын захиргаа нь Сайд нарын Зөвлөлийн шууд харьяалалд засаг захиргааны нэгж болохыг заасан

1931-2-26-нд Засгийн газрын эрхлэх товчооны 10-р хурлын 5-р зүйлээр орон нутгийн захиргааг шинэчлэн өөрчлөх хувьсгалт түр хороодыг түр хороо гэж нэрлэхээр тогтоожээ.

1931-9-21-нд УБХ-ын тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлын тогтоолоор Улаанбаатар аймгийн захиргааг гишүүд 11, орлогчдыг 5 хүнээр аймгийн захиргааны байгуулалтыг тэргүүлэгч, орлогч, нарийн бичгийн дарга, ерөнхий хэлтэс, цэргийн хэлтэс, хөдөө аж ахуйн хэлтэс, санхүүгийн хэлтэс, хотын нийтийн аж ахуйг эрхлэх хэлтэс, ардыг гэгээрүүлэх явдлын хэлтэс, Цагдан сэргийлэх явдлын хэлтэс, Улсын хянан байцаах бүртгэлийг Эрхлэх товчоо зэрэг зохион байгуулалтаар тогтоожээ.

1932 оны 10 сард Улаанбаатар хотын захиргааг Төв аймагтай нэгтгэж Улаанбаатар аймгийн Захиргаа болгосон.

1933 оны 12 дугаар сарын 29-нд Сайд нарын Зөвлөлийн 42 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл ээр 1930 онд батлагдсан Улаанбаатар хотын захиргааны дүрмийг шинэчлэн баталж, эл дүрэмд хотын захиргаа нь Сайд нарын Зөвлөлийн шууд харьяалалд засаг захиргааны нэгж болохыг заасан бөгөөд бүтцийг нь:

Цагдан сэргийлэх газар

Шүүх

Прокурор зэрэг байна.

1937 оны 2 дугаар сарын 13-нд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, СнЗ-ийн хамтарсан 4/2 дугаар тогтоолоор хотын захиргааг өөрчлөн “Нийслэл Улаанбаатар хотыг захирах яам” болгохоор тогтоосон байна.

1937 оны 2 сарын 5-нд СнЗ-ийн тогтоолоор Улаанбаатар хотын Захиргааны эрхийг өргөтгөн яамны эрх хэмжээнд хүргэж, хотыг захирах яам хэмээн нэрлэж яамны даргыг СнЗ-ийн жинхэнэ гишүүн болгожээ.

1937 оны 05 дугаар сарын 4-нд Улсын бага хурлын тэргүүлэгчдийн хурлаар Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталсан ба үндсэн хуулийн дагуу нийслэл хотын яам нь хотын ба хороодын хуралаар батлагдахаар заажээ.

1937 оны 02 дугаар сарын 13-нд Сайд нарын Зөвлөлийн 2 дугаар хурал, Улаанбаатар хотын Тэргүүлэгчдийн 4 дүгээр тогтоолоор 02 зүйлээр Улаанбаатар хотын захиргааг өөрчлөн "Улаанбаатар хотыг захирха яам" болгосон.

1937-4-23-нд Сайд нарын Зөвлөлийн 12 дугаар хурлын 4-р зүйлээр Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ.

Мөн яам нь Сайд нарын /Зөвлөлийн гишүүн байна гээд дотоод байгуулалтыг /

Тусгай дүрмээр хотын хэмжээнд дээр ажиллах газрууд

- Хотын прокурорууд

- Хотын шүүх таслах газар

1937-5-4-нд УБХ-ын тэргүүлэгчдийн хурлаар нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ.

1938 оны 04 дүгээр сарын 1-нд СнЗ-ийн хуралаар хот сайжруулах комиссын төслийг хэлэлцээд баталсан.

1939 оны 3 сард улсын 22 дугаар бага хурлын тогтоолоор "хотыг захирах яам" хэмээн нэрлэхийг "Улаанбаатар хотын захиргаа" хэмээн нэрлэх болсон.

1940 онд батлагдсан БНМАУ-ын үндсэн хуулиар "Улаанбаатар хотын бага хурлын тэргүүлэгчид" хэмээн тогтоосон.

1977-2-11-нд Сайд нарын Зөвлөлийн 40-р тогтоолоор аймаг, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитрын дүрмийг баталж арбитрчдийн үүргийг аймаг, хотын шүүхийн даргад хавсруулан гүйцэтгүүлэхээр тогтоожээ.

1992 оны 25-р тогтоолыг үндэслэн Нийслэл хотын 4 районыг 6 болгож, Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааг Нийслэл хотын Засаг даргын тамгын газар болгон орон тоо зохион байгуулалтанд доорхи өөрчлөлтийг хийжээ. Үүнд Хянан байцаах хэлтэс

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны тухай "Монгол улсын Засгийн газрын 1994.оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 229 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албыг тусд нь зохион байгуулан ажилуулах болсон нь засаг захиргааа, аж ахуйн үйлчилгээний ажлын ялгаа заагийг тогтооход чухал ач холбогдолтой болсон.

Нийслэлийн засаг даргын /ажлын алба буюу/ Тамгын газар нь Хянан байцаах хэлтэс